

НОГООН САНХҮҮЖИЛТИЙН ЗОХИЦУУЛАЛТ



Б.Дөлгөөн, Үнэт цаасны газрын дарга
Санхүүгийн зохицуулах хороо

ПАРИСЫН ХЭЛЭЛЦЭЭР, “АЛСЫН ХАРАА – 2050”

2030 он гэхэд
хүлэмжийн хийн нийт
ялгарлыг **27.2 хувиар**
бууруулах зорилт
тавьсан.

2022

“Тогтвортой санхүүгийн
үндэсний замын
зураг”-ийг баталсан.



2022

“Байгаль орчин нийгэм,
засаглал (БОНЗ),
Тогтвортой байдлын
тайлагналын удирдамж”-
ийг боловсруулсан.



БОНЗ, ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛЫН УДИРДАМЖ

МОНГОЛЫН КОМПАНИУДАД ЗОРИУЛАВ

2023

Тогтвортой хөгжлийн зорилт (ТХЗ)-уудын санхүүжилтийн таксономийг баталсан.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА, САНГИЙН САЙД, ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН
КОРПОРАЦИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны .1. дугаар .11.-ны өдөр Дугаар А-155/172/152/А-46 Улаанбаатар хот

"Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн
таксономи"-ийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 27² зүйлийн 5 дахь хэсгийн 5 дахь заалт, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2022 оны "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай" 65 дугаар тогтоолын 2.6 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны дүрмийн 3.2 дахь заалт, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажиллах дүрмийн 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи"-ийг хэвсралт ёсоор баталсугай.

2. Уг таксономийг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд туршилтын журмаар нэвтрүүлж, энэ хугацаанд холбогдох байгууллагуудтай хамтран таксономийн баримт бичигт шаардлагатай засвар, сайжруулалтыг тухай бүр тусгаж ажиллахыг Монголбанкны Дэд Ерөнхийлөгч (Г.Энхтайван), Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга (Т.Жамбаажамц), Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Ганбат), Хадгаламжийн даатгалын корпорацийн Захиргаа, удирдлагын газрын захирал (Х.Гэрэлт-Од) нарт тус тус даалгасугай.


3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Дотоод аудитын газар (А.Шижирмаа), Санхүүгийн зохицуулах хорооны Дотоод аудитын хэлтэс (Н.Соёлмаа), Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар (Б.Доржсэмбэд), Хадгаламжийн даатгалын корпорацийн Дотоод аудитын алба (У.Тамир)-нд тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ
Б.ЛХАГВАСҮРЭН

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА
Д.БАЯРСАЙХАН

САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН

ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН КОРПОРАЦИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
С.БААТАРСҮРЭН




**ТОГТВОРТОЙ, НОГООН
САНХҮҮЖИЛТИЙН
БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ**

НОГООН БОНДЫН ЗОХИЦУУЛАЛТ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

СЗХ нь 2021 онд “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ыг баталсан бөгөөд “Ногоон бонд” гаргах зохицуулалтыг нэмж тусгасан.




МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО

СЗХ нь “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-ын “Биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн журам”-ын нэмэлт өөрчлөлтийг 2023 онд батламжилсан.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

СЗХ нь “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ыг 2022 онд батламжилсан.



Ногоон бондын жишээ:



Санхүүгийн зохицуулах хорооноос 2023 оны 6-р сард Монголын хөрөнгийн зах зээлд анхны ногоон бонд гаргах зөвшөөрлийг ХААН Банканд олгосон. Энэхүү бонд нь олон улсын “Sustainable Fitch” байгууллагаар ногоон бондын зарчмуудтай нийцсэн талаарх дүгнэлт гаргуулсан гэдгээрээ онцлогтой юм.

НОГООН ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

2022 онд “Банк бус санхүүгийн байгууллагуудад зориулсан байгаль орчин, нийгмийн хүчин зүйлтэй холбоотой эрсдэлийн удирдлагын журам боловсруулах үлгэрчилсэн заавар”-ыг баталсан.



ББСБ салбар

5%

2030 он гэхэд ББСБ салбарын ногоон зээлийн багцыг нийт зээлийн багцын 5 хувьд хүргэх.



ББСБ салбарын нийт зээлийн **4.3%**-ийг ногоон зээл бүрдүүлж байна



115 тэрбум төгрөгийн
НОГООН ЗЭЭЛ

Цаашид ...



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

- Ногоон БОНД
- Ногоон ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН САН
- Ногоон IPO



ББСБ-ЫН ЗАХ ЗЭЭЛ

- Ногоон ЗЭЭЛ
- Ногоон ТҮРЭЭС



ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

- Гамшгийн эрсдэлийн
ДААТГАЛ
- Ногоон ДААТГАЛ /барилга,
тээврийн хэрэгсэл, ХАА/



БИЧИЛ САНХҮҮ

- Ногоон БИЧИЛ ЗЭЭЛ
- Ногоон БИЧИЛ ДААТГАЛ

НОГООН УГААЛТ



“Ногоон” гэсэн ойлголтыг буруу
зорилгоор ашиглахаас
сэргийлэх

Ногоон төслүүдийн
баталгаажуулалт

- ✓ Ногоон ФИНТЕК-ийн хөгжил
- ✓ Ногоон санхүүжилтийн мэдээллийн сан
- ✓ Ногоон санхүүжилтийн үнэлгээ
- ✓ Ногоон чадавх сайжруулах хөтөлбөр



АНХААРАЛ
ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА.